

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



I. ХӨДӨЛМӨР: Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 652 болж урьд оны мөн үеэс 140-н хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 62.1 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 23.0 хувь нь дээд, 8.9 хувь нь тусгай дунд, 37.6 хувь нь бүрэн дунд, 6.7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. Эхний сард 63 хүн шинээр бүртгүүлж, 18 хүн ажилд орсны дотор 13 нь шинэ ажлын байр байна.



II. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 1 сард 99 эх амаржиж, 99 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна. Халдварт өвчнөөр 58 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 159-өөр буурсны дотор гахай хавдар, салхин цэцэг, сүрьеэ, трихоминиаз зэрэг өвчлөлүүд буурсан байна.



III. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 1 сард 57 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 25-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 21 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 31.1 сая төгрөгийн хохирол учирсны 12.5 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэрэгт 30 хүн холбогдон сэжиглэгдсэний 73.3 хувь нь согтуугаар, 26.7 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 184 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 11 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 23 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



IV. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 2.0 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 3.6 хувиар, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.7 хувиар, эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7 хувиар, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 5.8 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 4.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Өнгөрсөн оны мөн үеийнхээс үнэ тарифын ерөнхий индекс 11.3 хувиар өссөн байна.



V. МӨНГӨ, БАНК: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 74.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2013 оны жилийн эцсээс 0.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 35.1 тэрбум төгрөг болсон нь 2013 оны жилийн эцсээс 1.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.



VI. ТӨРИЙН САНХҮҮ: Аймгийн төсвийн орлогод 5.0 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 2.6 хувиар биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 4.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.



VII. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Том малын зүй бус хорогдол 2014 оны 1 дүгээр сард аймгийн хэмжээнд 473 толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 мян.толгой буюу 83.3 хувиар буурсан байна. Тухай сард зүй бусаар хорогдсон нийт мал нь оны эхний 2491.4 мян.толгой малын 0.02 хувийг эзлэж, малын онд оролт 99.98 хувьтай байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Мөнххаан, Баруун-Урт, Асгат сумдад оны эхний малын 0.06 хувь нь тус тус хорогдоод байна. Харин Баяндэлгэр, Онгон, Сүхбаатар, Халзан, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумд малын хорогдолгүй гэсэн мэдээлэл өгсөн байна.



VIII. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.6 тэрбум төгрөгөөр доогуур, оны үнээр 5.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 1.3 тэрбум төгрөгөөр тус тус доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, ул боов, дулаан, нүүрс, том дээл, хүүхдийн дээл, яндан, пийшин, шургуулга, түлээний авдар, лааз, ваань, угаалтуур, түмпэн, тогооны таг, хогийн утгуур, агааржуулагч, хаалт, жигнүүр, галын хайч, хаалганы үйлдвэрлэлт нь урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.